



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

“Урлагийн наадам” зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүтээмж-хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд дүүргийн 35 жилийн ойг угтан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд “Урлагийн наадам”-ыг 2024 оны 04 дүгээр 25, 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Урлагийн наадам зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, оролцох аж ахуйн нэгж байгууллагуудын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү арга хэмжээнд ажилтан, албан хаагчдын санал санаачилгыг дэмжин бүрэн хамруулж, зохион байгуулалттай оролцохыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт, Урлагийн наадмыг зохион байгуулах байр, шүүх мэргэжлийн шүүгчдээр ханган ажиллахыг Соёлын ордон (Б.Алтанцоож)-д үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А. СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 41/27 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



### ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Алтанцоож	Соёлын ордны захирал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 4627 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН  
АЖИЛТАН АЛБАН ХААГЧИД, ИРГЭДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УРЛАГИЙН НААДМЫН УДИРДАМЖ**

**НЭГ. ЗОРИЛГО**

Бүтээмж-хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойг угтан аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчид, иргэдийн урлагийн авьяасыг нээн илрүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дүүргийн 35 жилийн ойн урлагийн тоглолтод оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахад оршино.

**ХОЁР. ХУГАЦАА**

Урлагийн наадмыг 2024 оны 04 дүгээр сарын 25, 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулна.

**ГУРАВ. ЯВАГДАХ ГАЗАР**

Дүүргийн Соёлын ордонд

**ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ**

Багахангай дүүргийн бүх аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд

**ТАВ. УРЛАГИЙН НААДАМД ОРОЛЦОХ ТӨРӨЛ**

1. Найрал дуу
2. Хамтлаг бүжиг
3. Гоцлол бүжиг
4. Хамтлаг дуу
5. Гоцлол дуу
6. Хөгжим (Хамтлаг болон гоцлол хөгжмийн аль нэг төрлөөс сонгож оролцоно.)
7. Монгол ардын дуу (Уртын болон богинын дуу сонголтоор)
8. Ардын язгуур урлаг
9. Уран уншлага

**ЗУРГАА. ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Мэргэжлийн шүүгч нар шүүн явуулна.

Урлагийн үзлэгт байгууллага, аж ахуйн нэгж нь хамт олноо өндөр түвшинд зохион байгуулж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулна.

Байгууллага, аж ахуйн нэгжүүд нь урлагийн үзлэгт батлагдсан хуваарийн дагуу 40 минутын хугацаанд багтаасан тоглолтын хөтөлбөртэйгээр оролцоно.

Техникийн зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, байгууллагуудын оролцох дарааллыг сугалуулна.

**ДОЛОО. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хуваарийн дагуу үзүүлбэрээ үзүүлэх байгууллага аж ахуйн нэгжээс тухай төрөлд оролцогсдын нэрс, оролцох төрлийн дагуу (хөтөлбөр) мэдүүлгийг гарган 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Соёлын ордонд ирүүлсэн байна.

### **НАЙМ. ҮНЭЛГЭЭ**

Байгууллага хамт олны зохион байгуулалт, хувцасны жигдрэлт, аяны сонголт, тайзны соёл, тухайн үзүүлбэрийн илэрхийлэл, ур чадвар, үзэгчидтэй харилцаж байгаа байдал зэргийг харгалзан шүүгч нар үнэлгээг өгнө.

### **ЕС. ДҮН ГАРГАХ**

Төрөл тус бүрээр 1-3 дугаар байранд шалгарсан авьяастнуудад дүүргийн 35 жилийн ойн хүндэтгэлийн концертод оролцох урилгыг гардуулна. Багийн дүнгээр байр эзлүүлнэ.


1 дүгээр байр, Өргөмжлөл, 1.500.000 төгрөг

2 дугаар байр, Өргөмжлөл, 1.000.000 төгрөг

3 дугаар байр, Өргөмжлөл, 800.000 төгрөг



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1027 дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт



УРЛАГИЙН НААДАМД ОРОЛЦОХ АЖ АХУЙН НЭГЖ  
БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

Д/д	Байгууллагын нэр
1	Засаг даргын Тамгын газар
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Төрийн банк (1 дүгээр хороо)
3	44 дүгээр цэцэрлэг
4	"Хангай" цогцолбор сургууль
5	Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
6	Илч-Орд ОНӨААТҮГ
7	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
8	УСАТовчоо
9	1 дүгээр хороо (иргэд)
10	Ахмадын хороо
11	Онцгой байдлын хэлтэс
12	2 дугаар хороо (иргэд)
13	Замын 17 дугаар хэсэг
14	Багахангай Өртөө, ТЗ-ын эмнэлэг
15	Техник үйлчилгээний газар, Төрийн банк (2 дугаар хороо)
16	Татах хэсэг, БЗАУ анги, Ган зам дэлгүүр
17	Дохиолол холбооны 2-р анги, ЭЧВОД, 183 дугаар цэцэрлэг
18	207 дугаар цэцэрлэг, ЖДҮДТөв
19	Татварын хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Дотоод аудитын алба, Нийгмийн даатгалын газар, Газар зохион байгуулалтын алба, Боловсролын хэлтэс, Мал эмнэлэг
20	Эрүүл мэндийн төв
21	Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
22	БТСХороо, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Хаан банк